

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс хүчин төгөлдөр болсноор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/1713 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөл”-ийг “Ёс зүйн дэд хороо” болгон өөрчилсөн. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/118 дугаартай тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон бөгөөд энэ тухай мэдээллийг ХЗДХЯ-нд 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 1/9625, Ёс зүйн хороонд 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 9/9650 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Ёс зүйн дэд хороо 2024 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчилтэй холбоотой 15 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэн, "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төв"-д ирүүлсэн албан хаагчдын ёс зүйтэй холбогдолтой 27 гомдлын шийдвэрлэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавин гишүүд хуваарийн дагуу шалгасан. Гомдлын шийдвэрлэлтийн байдалд дүгнэлт хийж, холбогдох албан тушаалтанд заавар чиглэлийг хүргүүлсэн.

Мөн 2024 оны 03 дугаар сард “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)”-ийн төсөлд тусгах саналыг, 2024 оны 07 дугаар сард “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийн хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын төсөлд тусгах саналыг тус тус боловсруулан Ёс зүйн хороонд хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)”, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” болон Ёс зүйн хорооны 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийн хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ыг бүх гишүүдэд танилцуулан, байгууллагын сайтад байршуулсан.

Ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 06 дугаар сард Калифорнийн Их Сургуулийн сэтгэл зүйн магистр, ШУТИСургуулийн Сэтгэл зүйн тэнхимийн багш Б.Баярмаа “Ёс зүй ба харилцаа” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулж бүх гишүүдийг хамруулсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/-ийг баталсантай уялдуулан тус хорооноос “Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2024 оны төлөвлөгөө”-г нийт 8 арга хэмжээний

хүрээнд боловсруулж, 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хурлаар баталсан бөгөөд уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд албан хаагчдийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн хуудас”-ийг боловсруулж, төлөвлөгөөний хамт газар, хэлтсүүдэд хүргүүлсэн. Мөн Улсын бүртгэлийн байгууллагын соёл, ёс зүйн үнэт зүйлийг тодорхойлохын тулд байгууллагын соёл, ёс зүйн өнөөгийн байдлыг үнэлэх зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 8-15-ны өдрүүдэд бүртгэлийн байгууллагын албан хаагчдаас цахимаар судалгааг авч дүнг нэгтгэж байгууллагын соёл, ёс зүйн үнэт зүйлийг тодорхойлох ажлыг хийж, судалгааны дүнг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргад танилцуулсан.

Судалгаанд нийт 439 албан хамрагдсан бөгөөд уг судалгааны үр дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

1. Зөрчлийн хуудсыг хөтлүүлэх ажлыг эхлүүлж, мөрдүүлэх;
2. Удирдлагын түвшинд сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж чадавхижуулах;
3. Хамт олны уур амьсгалыг таатай болгох, соён гэгээрүүлэх хүрээнд Ёс зүйн дэд хорооны гишүүд нэгж дээр ажиллах;
4. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бодит гарсан зөрчил дээр тулгуурлан кейс боловсруулан контент бэлтгэн албан хаагчдад сурталчлан таниулах;
5. Байгууллагын ёс зүйн зөрчилгүй хамт олныг шалгаруулж, сурталчлах;
6. “Сэтгэл зүйч” ажиллуулах тухай судлаж, танилцуулах зэрэг болно.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим сэдвээр цахим мэдээллийг Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага, Төрийн албан хаагчийн үнэт зүйл, Ажлын байрны ёс зүй, Ажлын байрны ёс зүйг баримтлахад Удирдлагын үүрэг гэсэн дэд сэдвийн хүрээнд бэлтгэн 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр байгууллагын сайтад байршуулсан.

Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг баримтладаг, удирдлага, хамт олны эерэг хандлага, харилцаанд анхаардаг хамт олныг шалгаруулах зорилготой Удирдамжийг боловсруулан батлуулсан. Удирдамжид дурдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд авсан арга хэмжээний танилцуулгыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хийж Ёс зүйтэй хамт олныг шалгаруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон “Ёс зүйтэй хамт олон”-оор шалгарсан. Тус шалгаруулалтын хүрээнд хангалттай үнэлгээ авсан болон хангалтгүй үнэлгээ авсан нэгжүүдэд Дэд хорооны зүгээс Зөвлөмжийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн байгууллагад шинээр томилогдсон 12 албан хаагчдад зориулан зохион байгуулах сургалтын хөтөлбөрийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/184 дугаартай тушаалаар баталсны дагуу 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр “Төрийн албан хаагчийн харилцаа, төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөрчлийн хэлбэрүүд” сэдвээр тус хорооны гишүүн сургалт хийсэн.

Мөн Ёс зүйн хорооны гишүүн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, доктор (Ph.D), дэд профессор М.Цэрэнбаттай хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд" сэдвээр цахим болон танхим хосолсон сургалтыг зохион байгуулсан. Сургалтад цахимаар 21 аймаг, 9 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга болон, улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нараас 88 албан хаагч, танхимаар УБЕГ-ын газар хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, улсын бүртгэгч нараас 12 албан хаагч, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн 10 оюутан тус тус хамрагдсан.

Тайлант хугацаанд тус хороо нь 2024 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчилтэй гэх 15 гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэснээс 6 нь ёс зүйн зөрчилд тооцохгүй тухай, 9 нь ёс зүйн зөрчилд тооцох тухай дүгнэлтийг гаргасан. Ёс зүйн зөрчилд тооцох тухай дүгнэлтийг үндэслэн 5 албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3-т заасан “байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах” ёс зүйн хариуцлагыг, 1 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1-т заасан “өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах”, 2 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2-т заасан “нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах” сахилгын шийтгэлийг тус тус хүлээлгэсэн байна.